

**ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮНГИЙН ТАНИЛЦУУЛГА**
/2017 оны жилийн эцсийн байдлаар/

2018 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Монгол Улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж, хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж, УИХ-ын болон Байнгын хорооны болон Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл зэргийн байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын салбарт хэрэгжүүлэхээр хяналтад авсан заалтуудын биелэлт, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ өгч, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж гарган дэмжлэг үзүүлэх, бодит мэдээллээр хангах, тайланг нэгтгэн хэлэлцүүлэх зорилгоор ажиллав.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгон, 2017 оны эхний хагас жилийн байдлаар нэгтгэсэн Монгол улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж, хуралдааны тэмдэглэл, УИХ-ын болон Байнгын хорооны тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл зэрэг тогтоол, шийдвэрийн байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хэрэгжүүлэхээр хяналтад авсан заалтуудын хэрэгжилтийн гүйцэтгэлийн үр дүнг нотлох холбогдох материал судалгааг ашиглан, асуудал хариуцсан нэгжээс тайлбар, нэмэлт тодруулга авах зэргээр мэдээллийн чанарыг сайжруулж бататган, хэрэгжилтийн тайлан, мэдээллийг үндэслэн удирдлага, зохион байгуулалтын болон оролцогч талуудын хамтын ажиллагаа зэргийг харгалзан үнэлэв.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хэрэгжүүлэх 2017 оны жилийн эцсийн байдлаарх Монгол улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж, хуралдааны тэмдэглэл, УИХ-ын болон Байнгын хорооны тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл зэрэг тогтоол, шийдвэрийн нийт **105 тогтоол, шийдвэрийн 215 заалтыг** хяналтад авч хэрэгжилтийг үнэлэх ажлыг зохион байгуулав.

Дээрх заалтуудын 129(60.0%) нь бүрэн хэрэгжсэн, 33(15.3%) заалт хэрэгжих шатанд, 30(13.9%) заалт хэрэгжилт хангалтгүй, 12 заалтын хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй хэрэгжилттэйгээр дүгнэгдэж, биелэлтийн дүн дунджаар **85.08 хувь буюу 4.25 оноотой** үнэлэгдэж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.8 хувиар буурсан байна. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг шинээр мөрдөж эхэлсэнтэй холбоотойгоор үнэлгээний аргачлал өөрчлөгдсөн нь өмнөх онтой харьцуулахад үнэлгээний дүн буурсан үзүүлэлттэй байгааг онцлон тэмдэглэж байна.

3.1. Монгол улсын хуулийн хяналтад авсан 4 хуулийн 8 заалтаас 2 заалт бүрэн хэрэгжсэн, 3 заалт хэрэгжих шатанд, 3 заалт хэрэгжилт хангалтгүй хэрэгжилттэйгээр, биелэлтийн дүн дунджаар 62.5 хувь буюу 3.12 оноотой үнэлэгдэв.

3.2. Ерөнхийлөгчийн зарлигийн хэрэгжилтийн хяналтад авсан 8 зарлигийн 16 заалтаас 10 заалт бүрэн хэрэгжсэн, 3 заалт хэрэгжих шатанд, 3 заалт хэрэгжээгүй бөгөөд биелэлтийн дүн дунджаар 81.25 хувь буюу 4.06 оноотой үнэлэгдэв.

3.3. Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжийн хяналтад авсан 7 зөвлөмжийн 18 заалтаас 12 заалт бүрэн хэрэгжсэн, 3 заалт хэрэгжих шатанд, 2 заалт хэрэгжилт

хангалтгүй, 1 заалт хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй буюу биелэлтийн дүн дунджаар 86.47 хувь буюу 4.32 оноотой үнэлэгдэв.

3.4. Үндэсний аюулгүй байдлын хуралдааны тэмдэглэлийн хяналтад авсан 5 шийдвэрийн 14 заалтаас 9 заалт бүрэн хэрэгжсэн, 5 заалт хэрэгжих шатанд дүгнэгдэж, биелэлтийн дүн дунджаар 89.28 хувь буюу 4.46 оноотой үнэлэгдэв.

3.5. УИХ-ын тогтоолын хяналтад авсан 4 шийдвэрийн 5 заалтаас 4 заалт бүрэн хэрэгжсэн, 1 заалт хэрэгжих шатанд дүгнэгдэж, биелэлтийн дүн дунджаар 94.0 хувь буюу 4.70 оноотой үнэлэгдэв.

3.6. УИХ-ын Байнгын хорооны тогтоолын хяналтад авсан 10 шийдвэрийн 52 заалтаас 29 заалт бүрэн хэрэгжсэн, 9 заалт хэрэгжих шатанд, 6 заалт хэрэгжилт хангалтгүй, 8 заалт хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй дүгнэгдэж, биелэлтийн дүн дунджаар 84.31 хувь буюу 4.21 оноотой үнэлэгдэв.

3.7. Ерөнхий сайдын захирамжийн хяналтад авсан 1 тогтоолын 1 заалтаас 1 заалт бүрэн хэрэгжсэн буюу биелэлтийн дүн дунджаар 100 хувь буюу 5.0 оноотой үнэлэгдэв.

3.8. Засгийн газрын тогтоолын хяналтад авсан 35 шийдвэрийн 45 заалтаас 31 заалт бүрэн хэрэгжсэн, 1 заалт хэрэгжих шатанд, 11 заалт хэрэгжилт хангалтгүй, 2 заалт хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй дүгнэгдэж, биелэлтийн дүн дунджаар 81.39 хувь буюу 4.07 оноотой үнэлэгдэв.

3.9. Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн хяналтад авсан 31 шийдвэрийн 45 заалтаас 31 заалт бүрэн хэрэгжсэн, 8 заалт хэрэгжих шатанд, 5 заалт хэрэгжилт хангалтгүй, 1 заалт хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй дүгнэгдэж, биелэлтийн дүн дунджаар 86.59 хувь буюу 4.33 оноотой үнэлэгдэв.

Дөрөв. Дүгнэлт

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хэрэгжүүлэх 2017 оны жилийн эцсийн байдлаарх Монгол улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж, хуралдааны тэмдэглэл, УИХ-ын болон Байнгын хорооны тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл зэрэг тогтоол, шийдвэрийн нийт 105 тогтоол, шийдвэрийн 215 заалтыг хяналтад авч хэрэгжилтийг үнэлэх ажлыг зохион байгуулав.

Дээрх заалтуудын 129(60.0%) нь бүрэн хэрэгжсэн, 33(15.3%) заалт хэрэгжих шатанд, 30(13.9%) заалт хэрэгжилт хангалтгүй, 12 заалтын хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй хэрэгжилттэйгээр дүгнэгдэж, биелэлтийн дүн дунджаар 85.08 хувь буюу 4.25 оноотой үнэлэгдэж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.8 хувиар буурсан байна. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг шинээр мөрдөж эхэлсэнтэй холбоотойгоор үнэлгээний аргачлал өөрчлөгдсөн нь өмнөх онтой харьцуулахад үнэлгээний дүн буурсан үзүүлэлттэй байгааг онцлон тэмдэглэж байна.

Тав. Зөвлөмж

1. “Хууль тогтоомжийн тухай” хуулийн дагуу цаашид шинээр боловсруулж буй хууль тогтоомж, хөтөлбөр, төслийг боловсруулах, хэрэгцээ шаардлагыг урьдчилан судлах, үр нөлөөг үнэлэх зэрэг аргачлалыг үндэслэн, шинжлэх ухааны үндэслэлтэй, нийгэм эдийн засагт ач холбогдолтой, хэрэгжих бүрэн боломжтой, хэрэгжилт нь үр өгөөжтэй байх зэрэг тусгай шаардлагыг тавих нь хууль тогтоомж бүрэн хэрэгжих үндэслэл болж буйг анхааран ажиллах, ажлын явц, үр дүн удаашралтай байгаа хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, гүйцэтгэлийг сайжруулж үр дүнг дээшлүүлэх,

2. Хууль тогтоомжийн заалтыг хэрэгжүүлэх төсөв хөрөнгийг жил бүр заавал тусган, хэрэгжүүлэхэд санхүүгийн асуудал хүндрэлгүй байх хууль тогтоомж батлах-хэрэгжүүлэх-төсөвлөх гурвалсан уялдаа холбоог сайжруулах,

3. Төрийн албан хаагчдын ажлын төлөвлөлт, тайлагналт зэрэгт сургалт зохион байгуулж, мэдлэг мэдээллээр хангах, баримт бичиг боловсруулах үр чадварыг дээшлүүлэх, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг судалгаа, нотолгоо, баримтад тулгуурлан

үнэн зөв тайлагнаж дадах, нэгжийн дарга нар бүх түвшинд ажлын гүйцэтгэлд хяналт тавих, мэргэжил аргазүйн зөвлөгөө, зөвлөмж өгч дотоод хяналтыг сайжруулах, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын чиг үүрэг, тогтолцоог улам боловсронгуй болгоход Төрийн албаны зөвлөлтэй хамтран журам, аргачлал гарган ажиллах, тайлан хэрэгжилтийн талаар товч тодорхой, заасан хугацаанд мэдээлэх, тайлагнах үүрэгтэйг төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм болон бусад дүрэм, журамд оруулж тусгах,

4. ЗГХЭГ-т хүргүүлсэн тогтоолын төсөл болон зарим яамдын хамтран баталж хэрэгжүүлэх журам, аргачлалууд, хуулийн төсөл зэрэг нь тодорхойгүй шалтгаанаар батлагдахгүй удаашрах зөрчил, дутагдлыг арилгах ажлын уялдааг сайжруулах, онцгойлон анхаарч ажиллах,

5. ЗГХЭГ-аас бусад Ерөнхийлөгчийн Тамгын газар, УИХ-ын Тамгын газартай нягт хамтран ажиллаж, хэрэгжилт тогтмолжсон, бүрэн хэрэгжсэн, цаг үеийн шаардлагаар хэрэгжих боломжгүй болсон тогтоол, шийдвэрүүдийг дахин нягтлан хяналтаас хасч, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, захиргааны байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, эргэн мэдээлдэг байхад онцгойлон анхаарч ажиллах шаардлагатай байна.

---o0o---

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ ХОЛБОГДОХ ХУУЛЬ
ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН
/2017 оны жилийн эцсийн байдлаар/**

Хүснэгт 1

Хууль тогтоомж	Бүгд	Үүнээс									
		Монгол улсын хууль	Ерөнхийлөгчийн зарлиг	Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж	Үндэсний аюулгүй байдлын хуралдааны тэмдэглэл	УИХ-ын тогтоол	УИХ-ын Байнгын хорооны тогтоол	Ерөнхий сайдын захирамж	Засгийн газрын тогтоол	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	
Хяналтад авсан тогтоол шийдвэрийн тоо	105	4	8	7	5	4	10	1	35	31	
Хяналтад авсан нийт заалтын тоо	215	8	16	18	14	5	52	1	45	45	
Үүнээс	Бүрэн хэрэгжсэн 100.0%	129	2	10	12	9	4	29	1	31	31
	Хэрэгжих шатанд 70%	33	3	3	3	5	1	9		1	8
	Хэрэгжилт хангалтгүй 30%	30	3	3	2			6		11	5
	Хэрэгжээгүй 0%										
	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	12			1			8		2	1
Биелэлтийн дүн (%)	85.08	62.50	81.25	86.47	89.28	94.0	84.31	100.0	81.39	86.59	
Оноо	4.25	3.12	4.06	4.32	4.46	4.70	4.21	5.00	4.07	4.33	

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР